



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар Н/143

Улаанбаатар хот

Хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Фармакопейн хорооны бүрэлдэхүүн”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/67, 2019 оны А/208 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

03 Эрүүл мэндийн сайдын 2021 оны
... сарын ... өдрийн ... дугаар тушаалын
хавсралт



ФАРМАКОПЕЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
- Орлогч дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмийн чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан дэд дарга;
- Нарийн бичгийн дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм үйлдвэрлэлийн хэлтсийн дарга;
- Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторийн дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
- Шинжлэх ухааны академи, Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, Эм зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Дүнгэрдорж /зөвшилцсөнөөр/;
- Эм судлалын хүрээлэнгийн захирал, Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, Эм зүйн ухааны доктор, профессор С.Цэцэгмаа /зөвшилцсөнөөр/;
- Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Химийн ухааны доктор, дэд профессор Г.Одонтуяа /зөвшилцсөнөөр/;
- Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн ургамлын аймаг, ангилал зүйн салбарын эрхлэгч, Биологийн шинжлэх ухааны доктор, профессор Э.Ганболд /зөвшилцсөнөөр/;

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн
Эм зүйн сургуулийн багш, Эм зүйн ухааны доктор,
профессор Д.Энхжаргал /зөвшилцсөнөөр/;

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн
гүйцэтгэх захирал, Анагаахын шинжлэх ухааны
доктор, дэд профессор Ч.Чимэдрагчаа
/зөвшилцсөнөөр/;

Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн захирал,
Монголын анагаах ухааны академийн гишүүн, Эм
зүйн ухааны доктор, профессор Л.Цэрэндулам
/зөвшилцсөнөөр/;

“Эм хангамжийн байгууллагын холбоо”-ны тэргүүн,
Эм зүйн шинжлэх ухааны доктор, профессор
Д.Цэндээхүү /зөвшилцсөнөөр/;

Эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны
гишүүн, эрүүл ахуйч, микробиологич, тэргүүлэх
зэргийн эмч Д.Сэлэнгэ /зөвшилцсөнөөр/;

-----xxxxx-----